

**АВТОТЭЭВРИЙН ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ ТОВЧООГООР
ТҮҮХИЙ НҮҮРС ТЭЭВЭРЛЭН НЭВТРҮҮЛЭХ ЖУРМЫН САНАЛ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Засгийн газрын түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаартай тогтоолын холбогдох заалтыг хэрэгжүүлэх, түүхий нүүрсийг тээвэрлэх үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахтай холбогдсон түүхий нүүрсийг тээвэрлэхэд зарлагын баримтыг үндэслэн эрхийн бичиг олгох, хэрэглэхэд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэ журам нь Улаанбаатар хотын, агаарын чанарыг сайжруулах төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт дээр үйл ажиллагаагаа явуулж байгаа цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мөрдөгдөнө.
- 1.3. Түүхий нүүрс тээвэрлэхэд цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл, зарлагын баримтыг үндэслэн эрхийн бичиг олгоно.
- 1.4. Энэ журам нь Баянзүрх дүүргийн 20, Сонгинохайрхан дүүргийн 21, Хан-Уул дүүргийн 12, 13,14 дүгээр хороодын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад хамаарахгүй болно.

ХОЁР. Журмын нэр томъёоны тодорхойлолт

- 2.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 2.1.1. Түүхий нүүрс тээвэрлэх зарлагын баримт /цаашид “зарлагын баримт” гэх/ гэж уурхай болон амнаас гарсан түүхий нүүрсийг цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын баримт бичгийг үндэслэн өгсөн баримтыг;
 - 2.1.2. Түүхий нүүрс тээвэрлэх эрхийн бичиг /цаашид “эрхийн бичиг” гэх/ гэж орон нутгаас нийслэлийн хотын төвийн 6 дүүрэгт зохих журмын дагуу түүхий нүүрсийг оруулж ирэх, тээвэрлэхэд олгосон баримт бичгийг;
 - 2.1.3. “Тээвэрлэгч” гэж цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага;

ГУРАВ. Эрхийн бичигний загвар

- 3.1. Эрхийн бичиг нь уурхайн нэрийг илэрхийлсэн хэвлэмэл сери, дугаартай байна.
- 3.2. Эрхийн бичгийн бүрдүүлбэр нь тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын нэр, түүхий нүүрсний төрөл, регистр, хаяг, нүүрсний хэмжээ, тээвэрлэж дуусах хугацаа, буух газрын нэр, байршилыг зааж өгсөн байна.
- 3.3. Эрхийн бичиг нь үлдэх, олгох тасалбар гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.
- 3.4. Эрхийн бичиг олгох, үед тэмдэглэгээ хийх хэсэг, хяналтын хэсэг, шалгасан тухай тэмдэглэл хийх хэсэг болон санамж, үлдэх хувь гэсэн 5 үндсэн агуулгатай байна.
- 3.5. Эрхийн бичгийн хяналтын хэсэгт 1-100 гэсэн тоо бүхий нэг, 1-10 гэсэн тоо бүхий нэг нийт 2 баганатай хүснэгт байна. Энэ нь тухайн тээврийн хэрэгсэлд ачих түүхий нүүрсний хэмжээг заана.

ДӨРӨВ. Эрхийн бичгийг олгох

- 4.1. Эрхийн бичгийг олгохдоо түүхий нүүрсний хэмжээг тн-оор тооцно.

- 4.2. Эрхийн бичгийг үндэслэн тээврийн хэрэгсэл тус бүрээр олгоно.
- 4.3. Тээвэрлэгч чиргүүл ашиглаж байгаа тохиолдолд эрхийн бичгийг нийт тээвэрлэгдэх түүхий нүүрсний хэмжээгээр бичнэ.
- 4.4. Эрхийн бичгийг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад олгосон талаарх мэдээллийг уурхай, амны эрх бүхий албан тушаалтан олгосон өдрөөс мэдээллийн санд байрлуулна.
- 4.5. Түүхий нүүрсийг тээвэрлэх зайнаас хамаарч эрхийн бичиг хүчинтэй байх хугацааг тогтооно. Тогтоохдоо Монгол улсын батлагдсан авто замын сүлжээний километрээр тооцон 300 километр тутамд хоногийн 24 цагаар тооцон хүрэх цэг хүртэл цаг, минутыг тавьж өгнө.
- 4.6. Түүхий нүүрснийг төмөр замаар тээвэрлэх тохиолдолд эрхийн бичгийн хүчинтэй байх хугацаа 7 хоног байна.
- 4.7. Эрхийн бичигт түүхий нүүрсний нэр төрөл, тоо хэмжээг цэвэр гаргацтай, засваргүй бичнэ.
- 4.8. Эрхийн бичгийг урьдчилан болон нөхөн олгохыг хориглоно.

ТАВ. Түүхий нүүрс тээвэрлэх эрхийн бичгийг хэвлүүлж тараах, тайлагнах

- 5.1. Тухайн жилд тээвэрлэх эрхийн бичгийн тоог түүхий нүүрс хэрэглэх дээд хязгаарыг орон нутаг дахь мэргэжлийн алба тогтоон хэвлүүлнэ.
- 5.2. Мэргэжлийн албаны эрх бүхий албан тушаалтан эрхийн бичгийн олголт, үлдэгдлийн тайланг улирал тутамд гаргаж, улирал бүрийн эхний сарын 10-ны дотор Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт ирүүлнэ.

ЗУРГАА. Эрхийн бичигт хяналт тавих

- 6.1. Эрхийн бичиг хүчинтэй эсэхэд эрх бүхий улсын байцаагч, цагдаагийн байгууллагын албан хаагч хяналт тавьж ажиллана.
- 6.2. Эрхийн бичгийн олголтод Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газар, эрх бүхий улсын байцаагч, цагдаагийн ажилтан хяналт тавина.
- 6.3. Түүхий нүүрс тээвэрлэгч нь төв замаар явж дамжин өнгөрөх хяналтын цэгүүдэд зарлагын баримт, эрхийн бичиг болон холбогдох бусад баримт бичгийг эрх бүхий улсын байцаагч, цагдаагийн ажилтан нарт шалгуулна.
- 6.4. Тухайн нүүрсийг тээвэрлэхэд эрхийн бичиг дагалдах бөгөөд зөвхөн ачсан түүхий нүүрстэй хамт байхад хүчинтэй байна.
- 6.5. Эрхийн гэрчилгээгүй, гэрчилгээг баталгаажуулаагүй, дамжин өнгөрөх хяналтын цэгт бүртгүүлээгүй, хугацаа хэтэрсэн зэрэг зөрчилтэй түүхий нүүрсийг зөвшөөрөлгүй тээвэрлэсэн гэж үзнэ.
- 6.6. Дамжин өнгөрөх цэгүүдэд эрх бүхий улсын байцаагч, цагдаагийн ажилтан нар эрхийн бичгийг шалгасан тухай тэмдэглэл хийнэ.

6.8. Эрхийн бичгийн ар талд байгаа шалгасан тухай тэмдэглэлийн эхний босоо хүснэгтийг бичихдээ тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар түүхий нүүрсний нэр, төрөл, тоо хэмжээ, худалдан авсан зарлагын баримттай тулган шалгаж зохих тэмдэглэгээ хийнэ.

6.9. Шалгасан тухай тэмдэглэлийн бусад хүснэгтийг асуултын дагуу гаргацтай бөглөн, он сар, цаг минутыг тодорхой тэмдэглэн, гарын үсэгний тайлалыг бичиж гарын үсэг зуран тэмдгийг гаргацтай тод дарна.

6.10. Тухайн уурхай, амны эрх бүхий албан тушаалтан түүхий нүүрсний тээвэрлэгч этгээдэд замын постуудыг зааж өгснөөр батлагдсан төв замаар явж тухайн постуудад бүртгүүлж эрхийн бичигт тэмдэглэгээ хийлгэнэ.

6.11. Цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлгүй, эрхийн бичиггүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэн Улаанбаатар хотын 6 дүүрэг, агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс тээвэрлэн оруулж ирэхийг хориглоно.

ДОЛОО. Хариуцлага

7.1. Энэ журмын хэрэгжилтэд эрх бүхий улсын /ахлах/ байцаагч, цагдаагийн ажилтан хяналт тавьж ажиллана.

7.2. Энэ журмыг зөрчсөн этгээдэд “Зөрчлийн тухай” хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.3. Эрхийн бичиг болон зарлагын баримтыг хуурамчаар үйлдэхийг хориглоно.